

П.Цэрэнбазар

БНХАУ-ын Жилиний Их Сургуулийн докторант

**АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГИЙН ТАЛААРХ ОЙЛГОЛТ БА
СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ**

... A considerable volume of literature did indeed appear during the 1970s, some proposing lifestyle as a theoretical concept and some exploring the idea empirically. Most of this work, however, appeared in fields other than leisure studies, including such diverse areas as: studies of migrant communities; urban studies; market research; futurology; community politics; tourism; and social theory in general.

There was, however, resistance to the use of the lifestyle concept: a 1989 paper published in *Leisure Studies*, suggesting that a Weberian approach to lifestyle could provide a framework for the development of leisure studies was firmly rejected by neo-Marxist and feminist scholars and has continued to be dismissed by critical sociologists and feminists. Despite this criticism, support for the lifestyle concept continued to grow during the 1990s. Mommaas (1999) related the concept to the work of Veblen, Weber and Simmel; Critcher appeared to modify his earlier position in suggesting that lifestyle was one of a number of "middle range" concepts which should be explored in leisure studies; a number of contributions to the discussion were made by Paré; Rojek suggested that the concept had survived some of its structural feminist critiques; and a substantial review of the concept was published in the journal *Leisure Studies*.

Түлхүүр ойлголтууд: Амьдралын хэв маяг, чөлөөт цаг,

Амьдралын хэв маягийн талаарх ойлголт, онолын тайлбарлалууд

Анх 1929 онд Австрийн сэтгэл судлаач А.Адлер “хүний амьдрах арга замыг дүрслэх явдал”¹ гэж амьдралын хэв маягийг тодорхойлсон байна. Тэрээр цааш нь амьдралын хэв маяг нь хүний онцлог, зан үйлийн арга барил, хэвшил дуршлын хосгүй нэгдлийг агуулж байдаг бөгөөд цогц байдлаар илрэх энэхүү чанар нь хүний амьдралын үл давтагдах хөрөг зургийг илэрхийлж байдаг гэж үзжээ².

Амьдралын хэв маягийн талаарх ойлголт цаг хугацааны хувьд 1800-аад оны үеэс эхлэн социологийн шинжлэх ухаанд нэвтэрч эхэлжээ. Гэсэн ч бие даасан судлагдахуун болж хөгжилтөө чөлөөт цагийн судалгаа, соёлын судалгааны хавсарга дор явж ирсэн бөгөөд орчин үед нийгмийн эрүүл мэнд, хэрэглэгчийн судалгааны гол объект болон хөгжиж байна.

Тухайлбал, Британий чөлөөт цагийн судалгаанд 1970-аад оноос хойш амьдралын хэв маягийн ойлголт онцгойлон тусгагдаж ирсэн байна³. Чөлөөт цагийн судалгааны түүхэн дэх гол онцлог нь бүлэг хувь хүмүүс ба хувь хүн чөлөөт цагаа өнгөрүүлэх хэв маягийг судлах эрэл хайгуулын шинжтэй байжээ. Чөлөөт цагийн зан үйлийг тайлбарласан нэлээд эхэн үеийн буюу 1960-аад оны хандлага нь энгийн хувьсагчтай буюу нас, орлого, нийгмийн анги, тоон хандлага давамгайлсан “эконометрик” маягийн, статистик загварчлал шаардсан байв. Хойд Америкт энэ загварчлал нь статистик тайлбарлалын түвшин багатай хийгдэж байсан бол Британий туршилтууд арай илүү найдвар төрүүлсэн. Гэсэн ч ихэнх социологичид энэ хандлагыг үр ашиггүй, онолын үндэслэл дутмаг гэж үзжээ. Чөлөөт цагийн судалгааг амьдралын хэв маягтай холбож үзэх энэхүү судалгааны уламжлал нь хэдийгээр ийм асуудалтай тулгарсан ч дараа дараагийн судалгаануудад тодорхой холбоос болж өгсөн юм. Британид 1970-аад оны үед чөлөөт цагийн судалгаанд хувь нэмрээ оруулж, онолыг дэлгэрүүлэгчид чөлөөт цагийн судалгааны талаарх санаагаа амьдралын хэв маягтай холбоогүй ч гэсэн чөлөөт цагийн зан үйлийг ажил, нийгмийн анги, гэр бүлийн амьдралын мөчлөг зэрэг өргөн цар хүрээтэй авч үзсэн.

¹ www.wikipedia.org

² О.Мягмар. Хүний хөгжлийн сэтгэл зүйн лекцүүд. 2012., УБ.

³ Anthony. J. VEAL, *Leisure, Culture and Lifestyle. Society and Leisure*, vol. 24, n° 2, 2001, p. 359-376

Чөлөөт цагийн онол, амьдралын хэв маягийн ойлголт, түүний хөгжлийн холбоо хамаарлын талаар Кеннет Робертс¹ ба Крис Рожек² нар цогц байдлаар нарийн судалжээ. 1970-аад онд Британий социологид хамгийн их анхаарал татсан салбар нь соёлын судалгаанаас чөлөөт цагийн асуудлыг нео-Марксист байдлаар дүгнэн шинжлэх явдал байв. Энд Кларк, Критчер нарын “Чөтгөр ажил хийж байна: Капиталист Британий чөлөөт цаг” (1985) хэмээх Марксист ангич шинжилгээний аргыг онолын гол загвар болгосон бүтээл оргилдоо хүрч байв. Харин нөгөө талд Кеннет Робертсийн “Орчин үеийн нийгэм ба чөлөөт цагийн өсөлт” (1978) хэмээх түүний өөрийн нэрлэснээр “олон ургалч” хэтийн төлөвийг харуулсан бүтээл онцгой няцаагдаж байлаа. Тэр дараах тайлбарыг хийсэн юм.

Британи болон бусад барууны нийгмүүдэд олон нийтийн янз бүрийн сонирхол оршиж байгаа бөгөөд тэд өөрсдийн ялгаатай нөхцөл байдлаас болж эсрэг тэсрэг сонирхолыг бий болгож байна. ...Амралт болон бусад хүрээнд олон нийт амьдралын хэв маягаа төлөвлөхөд чөлөөт цагаа ашиглаж, энэ нь хувь хүмүүс үнэт зүйл, үнэлэмжээ тунгаан бодоход туршлага болж байна. “Эрх чөлөөнөөс” гэдэг бол чөлөөт цагийн нөхцөл байдал. Гэвч энд бас зоосны эерэг тал болох хувь хүмүүст нөлөөлөх тэдний эдэлж байгаа “Эрх чөлөө рүү” ба эрүүл ухаанаар сэтгэвэл нийгэм-соёлын плурализм руу чиглүүлэх, янз бүрийн сонирхол бүхий олон нийт тэдний ялгаатай сонирхол, нөхцөл байдлын зүгээс тусгаж байгаа амьдралын хэв маягийг бүтээнэ гэжээ³. Робертсийн санааны далд утга нь амьдралын хэв маягийн ойлголтыг эргэлтэд оруулах арга зам байсан байна. 1970-аад онд үлэмж хэмжээний бүтээлүүдэд амьдралын хэв маягийн талаар бичих болсон ба тэдний зарим нь онолын ойлголт талаас нь, зарим нь эмпирик санаа талаас нь авч үзэж байв. Эдгээр ажлуудын ихэнх нь чөлөөт цагийн судалгааны салбарт, цагаачдын нийтлэгийн судалгаа, хотын судалгааны хүрээнд хийгдэж байсан ч зах зээлийн судалгаа, ирээдүй судлал буюу футурологи, улс төрийн бүлэглэл, аялал жуулчлал мөн нийгмийн ерөнхий онолын хүрээнд ч амьдралын хэв маягийн талаар авч үзэж байсан. Зиммелийн амьдралын хэв маягийн талаарх онолын хэлэлцүүлэг ч бас энд дурдагдах ёстой. Энэхүү бүтээл нь 20-р зууны эхэн үед бичигдсэн хэдий ч англи хэл дээрх орчуулга нь энэ цаг мөчид олны хүртээл болжээ.

Цаашлаад 1980-аад оны үеэс амьдралын хэв маягийн ойлголт социологичдын анхаарлыг илүү татаж, ерөнхийд нь нийгмийн бүтэцтэй холбож авч үзэх болсон. Үүний зэрэгцээ олон шүүмжлэгчид чөлөөт цагийн судалгааны ойлголттой холбож авч үзсэн. Крис Рожек “Веберийн социологийн шинжлэх ухаанд хамгийн удаан хугацаанд оршин үйлчилж байгаа бүтээлүүдийн нэг нь чөлөөт цаг бол амьдралын хэв маягийн талаарх ойлголт юм” гэж дурдсан байдаг. Энэ талаарх онолын маргаанд бодитой хувь нэмрийг Токарский, Пэйр, Оулет, Сью нар оруулсан. де ла Дюрантая чөлөөт цаг, амьдралын хэв маягийн олон зарчимт судалгаанд уриалан дуудсан бол Моорхаус үүнийг “...статус бүлэг ба амьдралын хэв маягийн ойлголтууд нь чөлөөт цагийн талаарх илүү шинжлэх ухаанч, илүү сайн шинжилгээг явуулах нэг арга зам юм гэж нотлосон байна. 1980-аад оны сүүлээр ОУ-ын Социологичдын Холбооны Судалгааны 13-р хороо энэхүү сэдвээр чухал баримтуудын цуглуулгыг хэвлэж гаргажээ.

1990-ээд онд амьдралын хэв маягийн талаарх ойлголтыг хэрэглэхэд эсэргүүцэлтэй байсан ч, 1989 онд хэвлэгдсэн “Чөлөөт цагийн судалгаа” бүтээлд амьдралын хэв маягийг судлах Веберийн хандлага нь чөлөөт цагийн судалгааны хөгжлийн үндсэн хандлагыг тодорхойлно гэж үзсэн нь нео-Марксист, феминист судлаачдын зүгээс хүчтэй няцаагдсан. Мөн шүүмжлэлт социологичид, феминистууд энэ сэдвийг судалгааны гадна үлдээсэн хэвээр байлаа.

Ийм шүүмжлэл байсан хэдий ч, 1990-ээд онд амьдралын хэв маягийн талаарх ойлголт өсч хөгжсөөр байсан. Моммаас Веблэн, Вебер, Зиммел нарын бүтээлтэй энэхүү ойлголтыг холбосон, Критчер өөрийн түрүү үеийн чөлөөт цагийн судалгааны “дунд түвшний” ойлголтуудын нэг байсан амьдралын хэв маягийн талаарх байр сууриа тухайн үеийн ажилтайгаа холбох хандлага үзүүлсэн, Пэйр олон тооны хэлэлцүүлгүүдийг явуулж, Рожек структур феминист шүүмжлэлийг даван гарсан ойлголтоо санал болгож, эцэст нь “Чөлөөт цагийн судалгаа” сэтгүүлд амьдралын хэв маягийн ойлголтын талаар нэлээд хэмжээний тойм хэвлэгдэн гарсан.

Дэвид Чаней амьдралын хэв маягийн талаарх томоохон хэмжээний боловсруулалтандаа ингэж дүгнэсэн байна: ...амьдралын хэв маягийн нийгмийн үзэгдэл нь орчин үежих үйл явцын

¹ Kenneth Roberts. Contemporary Society and the Growth of Leisure, 1978

² Chris Rojek. Leisure and Culture, 2000

³ K.Roberts, Contemporary Society and the Growth of Leisure. 1978, p. 86

хөгжилтэй нэгдмэл шинжтэй, амьдралын хэв маягийн санаа нь хувь хүний илэрхийлэл, онцлог шинжийг хайж олсон үлэмж хэмжээний илэрхийлэл төдий биш орчин үежих үйл явцын онцлог шинжийг тодорхойлох юм гэжээ.

Кеннет Робертсийн “Орчин үеийн нийгмийн чөлөөт цаг” 1999, Стивен Майлесийн “Өөрчлөгдөн буй дэлхийн залуучуудын амьдралын хэв маяг” 2000 номууд амьдралын хэв маягийн талаарх өнгөрсөн үеийн хэлэлцүүлэгийг өнөө үед авч ирсэн. Эндээс К.Робертсийн бүтээлд амьдралын хэв маягийн асуудлыг хэрхэн хөндсөнийг харвал дараах байдалтай байна.

“Орчин үеийн нийгмийн чөлөөт цаг” бүтээлдээ Робертс өөрийн түүрүү үеийн “том онолууд” болох Марксизм ба структур феминизмын няцаалтаа дахин баталж, харин чөлөөт цагийн сонголтыг авч үзэх зах зээлийн үйл явц нь ихэнх хүмүүсийн чөлөөт цагийн хэрэгцээ, хүсэлтэй нийцэж, илэрхийлж өгдөг гэсэн нео-либерал хандлагад илүү тал өгсөн. Энэ нөхцөл байдлыг шинжлэх онолын хүрээг хайсан тэрээр хоёр бүлэгт харуулсан ба нэгдүгээрт “Хэрэглээ ба Консумеризм”, хоёрдугаарт “Амьдралын хэв маяг ба Илэрхийлэл”. Хэрэглээ ба консумеризм гэсэн бүлэгтээ Робертс хэрэглэгчид бол зальтай маркетерүүдийн идэвхгүй хохирогчид гэж үзэх онолын хандлагаас татгалзсан. Харин тэрээр хэрэглэгчид бол орчин үеийн өрсөлдөөнт зах зээлийн орчинд хүмүүсийн чөлөөт цагийн хэрэгцээнд үр ашигтай таарах зүйлийг нийлүүлэгчдээс онцгой сонголтыг эдэлж байна гэж үзсэн. Энд социологийн гэхээсээ илүүтэй эдийн засгийн үндсэн шинжилгээг хийсэн байгааг онцлууштай юм. Эдийн засгийн онолын үндсэн зарчимд зах зээлийн үр ашиг ба үр нөлөөтэй байдал нь шударга энгийн байдал – хэдийгээр хэрэгцээгүй, бүхэлдээ буруу ч хэрэглэгчдийн сэдлийн талаарх төсөөллийг хардаг. (үндсэн нэр томъёо нь “эдийн засгийн рационализм”, “эдийн засгийн хүн”)

Амьдралын хэв маяг ба илэрхийлэл бүлэгтээ Робертс амьдралын хэв маягийн үзэгдэл нь нийгмийн анги, нас хүйс гэсэн чөлөөт цагийн шинжилгээний үндсэн бүтцийн ойлголтыг нөхөж чадна гэсэн хандлагаас татгалзсан. Тэрээр амьдралын хэв маяг бол шинэ бас өсч яваа нийгмийн үзэгдэл гэж номлодог консумеризм ба пост-модернизмыг баримтлагчдын үзэл бодлыг илүүд үзсэн. Түүний өөрчлөн зассан гол асуудал нь амьдралын хэв маягийн санааны цаг хугацааг наад зах нь Веберийн үед очих ба ойлгож буй амьдралын хэв маяг нь Британий 1960-аад оны “хиппи”, “моод”, хоёр дайны хоорондох жилүүдийн “флапперүүд” ба “бохэмианчууд” дэлгэрсэн түүрүү үед очно гэж үзсэн. Тэрээр энэ асуудлыг бүр “хотын хэсүүлчид” ба “танхайчууд”-ын үе хүртэл буюу өмнөх үеийн ижил бүлгүүд, 19-р зууны үе хүртэл хойш нь татаж огтхон ч эргэлзээгүй харьцуулж авч үзсэн. Гэвч бодит байдал дээр, амьдралын хэв маягийн тухай санаа нь шинэлэг, зөв, ашигтай байх албагүй. Амьдралын хэв маягийн асуудал нь консумеризм ба пост-модернизмтэй ижил төсөөтэй ч бэлгэ тэмдэг, хэв загвар, өнгөц байдал зэрэг бусад үзэгдлүүд энэ ойлголтод байдаг. Тэгэхээр эдгээр нь шинэ санаа биш ч орчин үеийн нийгэмд дүн шинжилгээ хийхэд үнэ цэнэтэй бөгөөд үр ашигтай гэж үзэгддэг юм.

Амьдралын хэв маягийг судлахдаа нийгмийн бүлгүүдийг адилтган судалж болох ба уламжлалт нийгмийн анги дахь бүлгүүд ерөнхийдөө адилтгах боломжтой мөн дунд эсвэл дээд ангийн бүлгүүд хоорондоо бага ялгаатай байдаг. Амьдралын хэв маягийн үзэгдлийн оршин буйг хүлээн зөвшөөрч эхлэх үед Робертс хөрөнгө чинээтэй, сайн боловсрол эзэмшсэн хүмүүс эдийн засгийн ба соёлын эх сурвалжаас өөрсдийн хэрэгцээг хангах асуудлыг харьцуулж үзэх нь хориотой гэж дүгнэсэн.

Амьдралын хэв маягийн судалгаанд хөндөгдөх нэг чухал асуудал бол тогтворгүй байдал юм. Робертс постмодерн нөхцөл байдалд эрчимтэй өөрчлөгдөж байгаа соёлын орчинд хүмүүс амьдралын хэв маягаа тогтворгүй байдлаар бүтээж байгаагаас үндэслээд, амьдралын хэв маягууд нь тогтворгүй байдлаар тодорхойлогдож байна гэж үзсэн. Энэ үзэгдлийг тэрээр “заналхийлэл” эсвэл “чөлөөт цагийн сүйрэл” гэдэгтэй адил санаатай байна гэж үзсэн. Гэвч хүмүүсийн амьдрал дахь хэрэгтэй, ашигтай байдал эсвэл нөгөө талаас өсөн нэмэгдэж буй тогтворгүй байдал нь амьдралын хэв маягийн талаарх ойлголттой холбоогүй асуудал юм. Хэрвээ амьдрал улам бүр хоромхон зуурын, тогтворгүй шинжтэй болбол амьдралын хэв маягийг судалж байгаа одоогийн хандлагууд нь энэ хандлагад “тохирох” болно. Энэ нь одоогийн энэ цаг үед амьдралын хэв маяг нь үр ашигтай, дүн шинжилгээ хийх боломжтой хэрэгсэл гэдгийг харуулж байгаа юм. Түүнчлэн тогтворгүй байдал нь нийгмийн шинжлэх ухааны судлаачдад гэнэт тулгарсан шинэ зүйл биш гэдгийг тэмдэглэж байна. Тогтворгүй байдал нь ба хотжилт, аж үйлдвэржилт, эдийн засгийн өсөлт бууралт, технологийн өөрчлөлт, ихэнх үеийг хамарсан дайнууд, мөн соёлын олон төрөлд гарсан оршихуйн өөрчлөлт зэргийг багтаагаад баруун дахь аж үйлдвэрийн хувьсгалын үеэс эхэлж яригдсан.

Робертсийн судалгаанд хөндөгдсөн дараагийн сэдэв бол хэв маяг. Британий судалгаанаас харахад ихэнх худалдан авагчид өөрсдийн худалдан авалтын сонголт нь “хэв маяг”-ийн үндсэн дээр үү, үнэ өртөг ба хэрэглээний өртөг дээр хийгдсэн үү гэдгийг мэддэггүй, тиймээс тэд өөрсдийн хэрэглээний үндсэн дээрээс амьдралын хэв маягаа бүтээж байна гэж хэлж чадахгүй байгаа нь илэрхий байна гэж үзжээ. Хэдийгээр тэдгээр хүмүүс гэрийн тавилга хэрэгслийн хэв маягийн талаар саяхнаас ойлголттой болж байгаа ч эхэн үеийн америкийн судалгаанууд зочны өрөөний байдлыг судлахыг санал болгодог. Гоо зүйн хэлбэртэй болсон болоогүй, ухамсартай ухамсаргүй, гэрийн хэв маяг, хувцаслалт нь ирээдүйд хийгдэх бусад судалгаанд гарцаагүй хэрэгтэй эмпирик асуулт болж өгөх юм.

Робертс өөрсдийгөө “жирийн” гэж үзэж, ямар нэгэн адилслын бүлэглэлд хамааруулдаггүй залуу хүмүүсийг судлаад, хүмүүс, ялангуяа залуу хүмүүс ухамсаргүйгээр амьдралын хэв маягийн бүлгүүдтэй адилсдаг гэсэн хандлагад шүүмжлэлтэй хандсан. Бүлгийн адилслын асуулт нь сонирхолтой бөгөөд цогц байдлаар тавигддаг. Психографик зах зээлийн судалгааны үндсэн дээр бүтсэн зарим амьдралын хэв маягийн загварууд нь амьдралын хэв маягийн бүлэг дэх хувь хүний ухамсарт адилсал нь хамааралгүй, хэрэглээ, хандлага, эдийн засаг, хүн ам зүйн мэдээлэл зэрэгт үндэслэн гишүүнчлэл тогтоосон байдаг. Хэрвээ бүлгийн адилслын талаар судалгаа хийх гэж байгаа бол давамгайлал нь нэмэгдэж байгаа “дунд анги”-г хүлээн зөвшөөрч, асуулгын хариултауд нь дан сонголттой байхад найддаг байсан. Бодит байдал дээр илүү нарийвчлалтай нийгмийн анги бүлгүүд мэргэжлийн ангиллын дагуу энгийн байдлаар тодорхойлогддог. Эцэст нь, бүлгийн адилслын талаарх хариулагдаагүй асуултууд энэ ойлголтыг хэрэгсэхгүй орхих эсвэл цаашид судлах шалтгаан болж өгөхгүй.

Робертс чөлөөт цаг хувь хүний адилслын үндсэн эх сурвалж болж чадна гэсэн ойлголтыг няцаах шаардлагыг эрж хайсан. Тэр амьдралын хэв маягийн ойлголт чөлөөт цагт зарим талаар голлох байр суурьтай ч хэрвээ энэ голлох байр суурь нь алдагдвал амьдралын хэв маягийн ойлголтын баталгаажилт алдагдана гэж дүгнэсэн. Амьдралын хэв маягийн судалгаанд чөлөөт цагийг ерөнхийд нь газарзүйн хүчин зүйл, мэргэжил, хэрэглээний түвшин, хандлага зэргийг багтаагаад нийгэм эдийн засаг, амьдралын мөчлөгийн үүднээс авч үзвэл энгийн нэгэн үзэгдэл гэж үздэг. Амьдралын хэв маягийн талаарх хэлэлцүүлэгт залуучуудад гол анхаарал хандуулах хэрэгтэй. Тэрээр Стивен Майлесийн залуучуудын чөлөөт цагийн зан үйл, хандлага, хэрэглээнд тулгуурласан судалгааны дүгнэлтийг эсэргүүцсэн. Энд “Залуучуудын амьдралын хэв маяг залуу хүмүүсийн амьдралд голлох үүрэгтэй, нарийн учир нь залуу хүмүүс амьдралын хэв маягийн чухлыг идэвхтэй ойлгож мэдэрдэг гэж дүгнэсэн. ...Мөн залуу хүмүүс амьдралын хэв маягаараа нийгмийн өөрчлөлт дэх бүтэц соёлын мухардмал байдлыг чиглүүлж байдаг¹ гэжээ.

Эцэст нь Робертс амьдралын хэв маяг бол шинжилгээний зайлшгүй чухал хэрэгсэл биш, учир нь уламжлалт шинжилгээнүүд бүх шаардлагатай тайлбарлалуудыг хийсэн гэж үзсэн. Нийгмийн анги, нас, хүйсийг авч үздэг чөлөөт цагийн зан үйлийн гол ялгаанууд чөлөөт цагийн тогтсон судалгааны зарчмын дүгнэлтүүд хүчтэй хэвээр батлагдсаар байна. Хүйс, нас, нийгэм-эдийн засгийн байр суурь нь анги доторх амьдралын хэв маягийн бүлгүүдийн хоорондын ялгааг гаргахаас илүү чөлөөт цагийн ялгааг гаргахад тодорхой холбогдож байна².

Амьдралын хэв маягийн судалгааны хамрах хүрээ

Амьдралын хэв маягийн судалгаа нь нийгмийн эрүүл мэнд, эдийн засаг, улс төр, зах зээл, хэрэглээ зэрэг олон асуудлуудыг багтаадаг. Энэ чиглэлээр судлаачид бүс нутгийн, улс орны, орон нутгийн түвшинд, насны ангилал, нийгмийн бүлгүүдээр ялгаатай судалгаануудыг явуулж иржээ.

Нийгмийн эрүүл мэндийн хүрээнд

Амьдралын хэв маягийн судалгааг нийгмийн эрүүл мэндийн хүрээнд нэлээд өргөн хүрээтэй судалдаг ч нийтээр хүлээн зөвшөөрсөн асуулгын багц одоогоор байхгүй байна. Энд 5 асуудлыг гол түлхүүр болгож авч үздэг нь тамхидалт, алкохолны хэрэглээ, биеийн хөдөлгөөн, эмийн хэрэглээ, хоолны дэглэм, биеийн ерөнхий эрүүл мэндийн асуудлууд оржээ. Түүнчлэн хөрөнгө чинээ буюу аж байдал, нийгмийн капитал, өвчний тархалт зэрэг асуудлуудыг сүүлийн үед нэлээд хамруулах болжээ.

Нийгмийн оролцооны хүрээнд

¹ Steven Miles, Youth Lifestyles in a Changing World, 2000 p. 159

² K.Roberts, Leisure and Contemporary Society, 1999 p. 212

Амьдралын хэв маягийн нийгмийн оролцооны байдлыг харуулсан судалгааны үндсэн чиглэлүүд нь өдөр тутмын үйл ажиллагаа, чөлөөт цагаа өнгөрүүлэх байдал, амралт - аялал жуулчлал, харилцаа холбоо - интернэт орчин, спорт, нийгмийн идэвх, оролцоо, шашин шүтэх байдал гэсэн 7 үндсэн асуудлыг гол хэмжигдэхүүн болгож авч үзсэн байна.

Дээрх асуудлуудыг амьдралын хэв маягийн судалгаанд багтааж авч үзэх нь эдийн засаг нийгмийн судалгаа, соёл, харилцаа холбоо, урлаг, спорт, тээвэр аялал жуулчлал, эрүүл мэнд, орон нутгийн удирдлага, боловсрол зэрэг нийгмийн салбаруудыг хамарч хүн амын үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлоход чиглэгдэх юм.

Хэрэглэгчийн судалгааны хүрээнд

Хэрэглэгчийн амьдралын хэв маягийн судалгаа нь мэдээллийн олон агентлагуудын арилжааны зорилгоор боловсруулж, цуглуулсан мэдээллүүд байдаг. Энэ мэдээлэл нь ихэвчлэн шууд маркетингийн үйл ажиллагаанд зориулагдсан байдгаараа бусад судалгаануудаас онцлогтой.

Хэрэглэгчийн амьдралын хэв маягийн судалгаа нь өргөн хүрээг хамарсан, түүврийн хэмжээ ихтэй байдаг. Хариултын түвшин 10-20 хувьтай, мэдээллийн эх сурвалж нь бүхэлдээ өнгөлөн далдлагдсан байдаг ч, судалгааны хариулт нь хазайлт ихтэй байдаг. Гэсэн ч энэ нь арилжааны зорилгоор хийгддэг, судалгааны зорилтот бүлэг нь хэрэглэгч байж, асуултууд нь тэдэнд нөлөөлөхүйцээр хийгддэг гэдгийг мартаж болохгүй.

Энэ эх сурвалжийг ашиглах олон тооны хувилбарууд бий. Үүнд:

- Тодорхой асуултуудыг мэдээллийн баазаас авах зорилгоор орон нутгийн мэдээллийг худалдаж авах
- Ирээдүйд судалгааны мэдээлэл цуглуулах зорилгоор тодорхой асуултуудад санхүүгийн дэмжлэг үзүүлэх

Жишээлбэл, Нэгдсэн Вант Улсын амьдралын хэв маягийн судалгааг удирдан явуулагч нь “Хэрэглэгчийн Мэдээлэл” бөгөөд энэ нь тус улсын хамгийн том шууд маркетингийн компаниудын нэг юм. Тэдэнд тус улсын 20 сая хувь хүний мэдээлэл байдаг ба хэрэглэгч бүр дээр 200 хувилбартай 4000 хэв шинжийн мэдээллийг сонгож гаргаж ирэх мэдээллийн бааз байдаг.